ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМАНД 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГС ЖИЛД ИРГЭД, АЖ АХУЙН НЭГЖЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДЛЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Тус яам, иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хариу өгөх ажиллагааг "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" Монгол Улсын хууль, бусад хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж байна.

2020 оны эхний хагас жилийн байдлаар хүлээн авсан өргөдөл, гомдол, тэдгээрийг шийдвэрлэсэн байдал, зохион байгуулж хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай мэдээ, танилцуулгыг тогтоосон журам, хугацааны дотор гаргаж, удирдлагуудад танилцуулан дүгнэлт, шийдвэр гаргуулж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Тус яаманд 2020 оны эхний хагас жилд нийт **243** өргөдөл, гомдол ирсэнээс **230** өргөдлийг шийдвэрлэсэн, хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн өргөдөл, гомдол байхгүй, **42** өргөдлийг бусад байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлсэн, **13** өргөдөл шийдвэрлэлтийн хуулийн хугацаа болоогүй /*хяналтад*/ байна. Нийт өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн биелэлт **94.6%** байна.

2020 оны эхний хагас жилд хүлээн авч, шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тайланг хавсралт 1, 2, 3-аар тус тус гарган хүргүүлж байна.

---ooOoo---

.....тоот албан бичгийн
нэгдүгээр хавсралт

Эрчим хүчний яаманд 2020 оны эхний хагас жилд иргэд, аж ахуйн нэгжээс Төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт	Үүнээс:				
			Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	Бусад
1	Эрчим хүчний яам	243	226	17	-	-	-
Тайлбар: 11-11төвөөс шилжиж ирсэн санал хүсэлтийг тайланд оруулаагүй болно. 2020 оны 06 дугаар сарын 30-ний өдрийн байдлаар							

---ooOoo---

.....тоот албан бичгийн
хоёрдугаар хавсралт

Эрчим хүчний яаманд 2020 оны эхний хагас жилд иргэд аж ахуйн нэгжээс Төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлт
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлсэн	Хугацаа хэтрүүлж /*сунгаж*/ шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй /*хяналтад*/	
1	Эрчим хүчний яам	243	230	42	-	13	94.6%

---ooOoo---

.....тоот албан бичгийн
гуравдугаар хавсралт

Өргөдөл, гомдол санал хүсэлтийн агуулга

д/д	Байгууллагын нэр	**Зонхилж байгаа асуудал / тоо, нийт өргөдөл гомдолд эзлэх хувь /**
1	Эрчим хүчний яам	Нийт 243 өргөдлөөс: Хүсэлт – 202 / 83,1 % Гомдол – 27 / 11,1% Санал – 12/ 4.9% Мэдээлэл- 2 /0.8% • Ажилд орох, гарах, чөлөө хүсэх, цалин хөлс,тэтгэвэр тэтгэмж, зэрэг төрийн албан хаагч,түүний ажиллах нөхцөл баталгаатай холбоотой асуудлаар – 119 /48.9% • Удирдлагын үйл ажиллагаа , Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар – 55 /22,6% • Түлш эрчим хүчний үйлдвэрлэл, холбоотой асуудлаар-41/16,8% • Тендер, Тусгай зөвшөөрөл, техникийн нөхцөлтэй холбоотой асуудлаар -16 /6,5% • Бусад асуудлаар -12/4,9%

---ooOoo---